



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020. 05. 01 № 1368
таний -ны № -т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР
ДЭВШИХ ИРГЭН Г.ЦОЛМОН
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвших иргэн Ганболдын Цолмонгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иргэн Ганболдын Цолмонгийн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн мөрийн

хөтөлбөр, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Ганболдын Цолモンгийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (2 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 2 хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮРӨРИОН
ГҮЙЦЭТГЭГЧ В. НОМИНБААТАР



**НИЙСЛЭЛИЙН ИТХ-ИЙН 2020 ОНЫ СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ГАНБОЛД ОВОГТОЙ ЦОЛМОНГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020 оны 7-р сарын 22-ны өдөр

Улсын нийслэл Улаанбаатар хот иргэнд ээлтэй эрүүл, аюулгүй тайван орчин бүхий, эдийн засаг нийгэм соёлын төв байх үүднээс 2 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр энэ удаагийн НИТХ-ын сонгуульд бие даан нэр дэвшихээр мөрийн хөтөлбөр боловсрууллаа.

Нэг. Иргэндээ ээлтэй хот

- 1.1 нийтийн эзэмшилийн зам талбайг хаасан аливаа хууль бүс аж ахуй нэгжийн үйл ажиллагааг зогсоон, нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлөх ажлыг идэвхижүүлэх
- 1.2 явган хүний гарц, зам талбайн аюулгүй байдал, төлөвлөлтөд анхаарч ажиллах
- 1.3 иргэдийн амьдрах эрүүл орчинг дээшлүүлэх зорилгоор нүхэн жорлонгүй нийслэл хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.4 Нийслэлийн хэмжээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор Нэг иргэн Нэг мод хөтөлбөрийг хэрэгжүүлэн, нийслэлийн гэр хороололын айл бүр хашаандaa мод тарих ажлыг идэвхижүүлнэ.
- 1.5 хог хаягдлын менежментийг боловсронгуй болгоно.
- 1.6 Гэр хорооллыг орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд газраа орон сууцаар солих иргэдийн газрын үнэлгээг бодитой зах зээлийн үнэлгээнд нийцсэн, тэдний эрх ашигийг хамгаалах чиглэлээр бие даагчийн хувьд идэвхитэй ажилана.
- 1.7 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аюулгүй байдал, тэдний бие даан нийгмийн харилцаанд оролцох боломжийг хангах зорилгоор нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн аж ахуйн нэгжийн орц гарц бүрийг өөрчлөх ажлыг саначлан хэрэгжүүлэх
- 1.8 иргэдээ сонсох, иргэний санал санаачлага, өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх хариу өгөх тогтолцоог боловсронгуй болгож, ухаалаг шийдэл нэвтрүүлнэ.
- 1.9 иргэний хяналтын тогтолцоог бий болгох замаар гэмт, хэрэг зөрчил, хууль бус үйлдлийг бууруулах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 1.10 цахим, ухаалаг засаглалыг хөгжүүлэх замаар төрийн үйлчилгээг илүү хялбар, уян хатан болгох ажлыг санаачилна.

Хоёр. Хүүхдэд ээлтэй хот

- 2.1 нийслэлийн дүүрэг хороо бүрийг хүүхдийн аюулгүй байдал стандартад нийцсэн тоглоомын талбайтай болгох
- 2.2 хүүхдийг зам тээврийн ослоос хамгаалах үрьдчилан сэргийлэх зорилгоор явган зам барих ажлыг гэр хороололд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 2.3 Хүүхдийг зам тээврийн ослоос хамгаалах үрьдчилан сэргийлэх зорилгоор сургууль, цэцэрлэг нийтийн тээвэрийн зогсоол, зам талбайд тусгай тэмдэг тэмдэглэгээ хийх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- 2.4 хүүхэд бүр сургууль цэцэрлэгт хамрагдах боломжийг нэмэгдүүлэхийн тулд улсын болон хувийн цэцэрлэг, сургуулийн бүтээн байгуулалтыг дэмжин ажилана.
- 2.5 хүүхдийн сурах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажилана.

Нэр дэвшигч: Г.Цолмон



- 2.6 хүүхэд хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг хувийн хэвшлийн байгууллагуудыг дэмжин ажиллах, тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзлүүлэх ажлыг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- 2.7 хүүхэд хөгжлийг дэмжих зорилгоор тэр чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг болон шинээр үйл ажиллагаа явуулах иргэн аж ахуй нэгжид нийслэлээс дэмжиж зөвшөөрөл олгосон бол хүүхдийн эрүүл, аюулгүй байдал хангасан эсэхэд тавих хяналын тогтолцоог сайжруулна.
- 2.8 дүүрэг хороо бүрээр хүүхдийн амьдралын орчин нөхцөлд дэлгэрэнгүй судалгаа хийж, судалааг цахим хэлбэрт шилжүүлэн дэмжлэг шаардлагатай хүүхэд бүрт хүрч ажиллах, хүүхдийн төлөө хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүн тайланг нэгтгэн нийтэд нээлттэй мэдээлдэг тогтолцоог бүрдүүлэх
- 2.9 хүүхэд хамгаалах ажлын хүрээнд эцэг эх, иргэн бүрийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх ажлыг иргэдийн сэтгэлгээнд өөрчлөлт хийх замаар хэрэгжүүлнэ.

Нэр дэвшигч: Г.Цолмон

